



МОНГОЛ УЛС
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

Г Удирдамж батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1.9, 81.1.13 дахь заалт, 81.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд нийт шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын дунд зохион байгуулах спортын арга хэмжээний удирдамжийг 1 дүгээр, "Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого" сэдэвт шүүхийн захиргааны ажилтны дунд зохион байгуулах хэлэлцүүлгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан удирдамжийн дагуу арга хэмжээг зохион байгуулахыг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2023 оны 20 дугаар тушаалаар байгуулагдсан Техник зохион байгуулалтын дэд ажлын хэсэг (Э.Зоригтбаатар)-т, арга хэмжээг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Гүйцэтгэх нарийн бичгийн дарга (Р.Батрагчаа)-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Р.ОНОНЧИМЭГ



Шүүхийн ерөнхий зөвлөлийн
даргын 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн
131. дугаартай тушаалын 1. дүгээр хавсралт

ШҮҮХИЙН СПОРТЫН ИХ НААДАМ
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Шүүгч, шүүхийн захиргааны ажилтнуудын дунд биеийн тамир, спортыг хөгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих, хамтын ажиллагааг бэхжүүлэх, шилдэг баг, тамирчдыг шалгарулахад Шүүхийн спортын их наадмын зорилго оршино.

Хоёр. Оролцох баг, тамирчид

2.1. Шүүхийн спортын их наадам /цаашид “Тэмцээн” гэх/-д бүх шатны шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөлийн баг, тамирчид оролцоно. Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн ахмадын холбооны баг, тамирчид сонирхсон төрөлдөө зочноор оролцож болно.

Гурав. Тэмцээний төрөл

- 3.1. Тэмцээнийг дараах 5 төрлөөр зохион байгуулна.
- 3.1.1. Сагсан бөмбөг /тус бүр 8 тамирчнаас бүрдсэн эрэгтэй, эмэгтэй баг/
 - 3.1.2. Волейбол /тус бүр 8 тамирчнаас бүрдсэн эрэгтэй, эмэгтэй баг/
 - 3.1.3. Ширээний теннис /эрэгтэй 1, эмэгтэй 1, холимог хос-1/
 - 3.1.4. Дартс /эрэгтэй 2, эмэгтэй 2/
 - 3.1.5. Шатар /эрэгтэй 2, эмэгтэй 1/

Дөрөв. Тэмцээн зохион байгуулах хугацаа

4.1. Шүүхийн ерөнхий зөвлөл тэмцээнийг 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулна.

Тав. Техникийн зөвлөгөөн

5.1. Техникийн зөвлөгөөн 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 10 цагт Шүүхийн ерөнхий зөвлөлийн 102 тоот хурлын танхимд болно. Орон нутгийн шүүхийн баг, тамирчдын төлөөлөгч цахимаар оролцоно.

5.2. Тэмцээн зохион байгуулах газар, өдөр, цагийг техникийн зөвлөгөөний үеэр багуудад тодорхой мэдэгдэнэ.

5.3. Баг, тамирчдын мэдүүлгийг удирдамжид хавсаргасан маягтын дагуу бүрдүүлж, 2023 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 17 цаг 30 минутын дотор gereltuya@judcouncil.mn хаягаар ирүүлсэн байна.

5.4. Тэмцээнд оролцогч баг, тамирчдын оноолтыг сугалаагаар тодруулна.

5.5. Ирүүлсэн мэдүүлэгтэй холбоотой маргаан гарвал техникийн зөвлөгөөнөөр эцэслэн шийдвэрлэнэ.

5.6. Техникийн зөвлөгөөний шийдвэр нь эцсийн шийдвэр байна.

5.7. Техникийн зөвлөгөөнөөс тогтоосон тогтолтын хуваарийг өөрчлөхгүй.

Зургаа.Тэмцээнд оролцох баг, тамирчид, тэдний үүрэг

6.1.Тэмцээнд тухайн шүүхэд томилогдсон шүүгч, 2023 оны 01 сарын 02-ны өдрөөс өмнө томилогдсон, нийгмийн даатгалын шимтгэл төлсөн шүүхийн захиргааны ажилтан оролцоно.

6.2.Сум дахь сум дундын шүүх тухайн аймаг дахь шүүхийн багтай хамтран оролцоно.

6.3.Мэдүүлэгт зааснаас өөр тамирчин оролцуулсан багийг тухайн төрлийн тэмцээнээс хасна. Тоглолтын дараа энэ зөрчил илэрсэн тохиолдолд зөрчил гаргасан багийн оноог тэглэж, эсрэг багийг хожсонд тооцно.

6.4.Тэмцээнд оролцох баг, тамирчид байгууллагын нэр бүхий хаяг, хувийн дугаартай жигд хувцастай байна.

6.5. Волейбол болон сагсан бөмбөгийн төрөлд 2-оос доошгүй шүүгч, шүүгч хүрэлцэхгүй тохиолдолд тамгын газрын дарга талбайд заавал тоглоно.

6.6.Дартсын тэмцээнд эрэгтэй 2, эмэгтэй 2 тамирчин оролцох ба багийн бүрэлдэхүүнд заавал 1-ээс доошгүй шүүгч эсвэл удирдах албан тушаалтан байна.

6.7.Сэлгээний тамирчны нэрсийг мэдүүлэгт заавал тусгасан байна.

6.8.Тэмцээнийг мэргэжлийн спортын холбооны шүүгч нар шүүнэ.

6.9.Тэмцээний үеэр баг, тамирчид тоглолт эхлэх цагийг нарийн баримтална. Баг, тамирчдыг талбайд гаражыг зарласнаас хойш 5 минутын дотор талбайд гарч ирээгүй тохиолдолд хожигдсонд тооцно.

6.10.Тамирчид ёс зүйг чанд баримталж, бие биедээ хүндэтгэлтэй хандаж, тэмцээний шүүгчийн тавьсан шаардлагыг биелүүлнэ. Шүүгчийн гаргасан шийдвэрийг эсэргүүцсэн, үндэслэлгүй маргаан үүсгэж бусдыг үл хүндэтгэсэн баг, тамирчныг тухайн тэмцээнээс хасна.

6.11.Санаатайгаар эсрэг багийн тамирчны биед гэмтэл учруулах үйлдэл хийснийг талбайн шүүгч тогтоосон тохиолдолд тухайн тамирчныг тоглолтоос хасна.

6.12.Тэмцээнтэй холбоотой гарсан маргааныг тэмцээний Ерөнхий шүүгч, зохион байгуулж буй ажлын хэсэг зөвшилцэж шийдвэрлэнэ.

6.13.Тэмцээний нээлт, хаалтын ажиллагаа тусгай хөтөлбөрөөр явагдана.

Долоо.Спортын төрлүүдийн заавар

7.1.Сагсан бөмбөг

Тэмцээнд оролцох багийг сугалаа сугалах журмаар хэсэгт хуваана. Оролцогч багийн тооноос хамаарч хэсэгт байх багийн тоо өөр байж болно. Үүнийг техникийн зөвлөгөөнөөр шийднэ. Тоглолтыг олон Улсын сонирхогчдын сагсан бөмбөгийн дүрмээр шүүх ба хагас шигшээ тоглолтуудын сүүлийн 2 минут “24” секундийн зарчмаар явагдана. Багууд хэсэг шалгарч хасгах журмаар явагдана.

Багууд хожлын оноо тэнцсэн тохиолдолд зөвхөн оноо тэнцсэн багуудын хоорондын тоглолтын оноог эрэмбэлж, хэсгээс нэг, хоёроор шалгаруулна. Хэсгийн тоглолт 2 үеэр талдаа

/бохир цагаар/ эрэгтэй 7, эмэгтэй 5 минутаар явагдана. Торгуулийн шидэлт, минутын амралтын үед тоглолтын цагийг түр зогсоно.

Хасагдах шатны тоглолтууд болон медалийн төлөөх тоглолтууд цэвэр цагаар явагдана. Тоглолтын үндсэн цаг дуусахад оноо тэнцсэн тохиолдолд 2 минут сунгана.

7.2. Волейбол

Тэмцээнд оролцох багийг сугалаа сугалах журмаар хэсэгт хуваана. Хэсэгт хуваагдсан багууд хэсэг дотроо тойргоор тоглож хамгийн өндөр оноотой эхний 2 баг дараагийн шатанд шалгарна. Багуудын оноо тэнцсэн тохиолдолд зөвхөн оноо тэнцсэн багуудын хоорондын хожлын харьцаагаар эрэмбэлнэ. Хэсгийн болон хасагдах шатны тоглолт 3 үеэр 15 оноогоор явагдана. 2 үе дараалан хожсон тохиолдолд 3 дугаар үеийн тоглолт явагдахгүй.

Медалийн төлөөх тоглолт 3 үеэр 21 оноогоор явагдана.

7.3.Ширээний теннис

Тэмцээнд оролцох тамирчдыг сугалаа сугалах журмаар хэсэгт хуваана. Хэсэгт хуваагдсан тамирчид хэсэг дотроо тойргоор тоглож хамгийн өндөр оноотой эхний 2 тамирчин дараагийн шатанд шалгарна. Хожил тэнцсэн тохиолдолд зөвхөн хожил тэнцсэн тамирчдын хоорондын онооны харьцаагаар эрэмбэлнэ. Тоглолт 3 үеэр 11 оноогоор явагдана. Эхний 2 үе дараалан хожсон тохиолдолд 3 дугаар үеийн тоглох явагдахгүй. Хагас шигшээ болон шигшээ тоглолт 5 үеэр 11 оноогоор явагдана.

Холимог хосын тоглолт дээрхтэй адил зарчмаар явагдана.

Тэмцээний дүнг ганцаарчилсан болон холимог хосын төрөл тус бүрээр шалгаруулна.

7.4 Дартс:

Дартсын тэмцээнийг тухайн төрлийн олон улсын дүрмээр явуулна. Тоглолтыг эхлүүлэх болон багуудын шидэлтийн тоо гүйцэж, ялагч баг тодроогүй тохиолдолд багийн ахлагч нар “Бухын нүд” шиднэ.

Тэмцээнд оролцох багийг сугалаа сугалах журмаар хэсэгт хуваана. Хэсэгт хуваагдсан багууд хэсэг дотроо тойргоор тоглож хожлоороо шалгарсан эхний 2 баг дараагийн шатанд шалгарна. Хэсгийн 1, 2 дугаар байрыг шалгаруулахад хожил тэнцсэн тохиолдолд аль нэгнийгээ хожсон баг нь 1 дүгээр байраар шалгарна. Хэрвээ 3 баг бие биээ тойрч хожин, нийт хожлын тоо тэнцсэн тохиолдолд тэдгээр багуудын хоорондын тоглолтын хожигдсон үеийг тоолж аль цөөн үе хожигдсон баг шалгарна. Бусад асуудлыг Техникийн зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ

7.5 Шатар

Шатрын тэмцээнийг тухайн төрлийн олон улсын дүрмээр явуулна. Бусад асуудлыг Техникийн зөвлөгөөнөөр шийдвэрлэнэ

Найм.Тэмцээний шагналын сан

8.1.Тэмцээний төрөл тус бүрд Нэг, Хоёр, Гуравдугаар байр эзлүүлж, медаль, өргөмжлөл олгоно.

8.2.Нийлбэр дүнгээр Нэгдүгээр байр эзэлсэн багт Цом, өргөмжлөл гардуулна, Хоёр, Гуравдугаар байрт шалгарсан багт өргөмжлөл, тусгай шагнал олгоно.

8.3. Волейбол, сагсан бөмбөгийн төрөлд эрэгтэй 1, эмэгтэй 1 шилдэг тоглогч, бусад төрөлд 1 онцлох тоглогчийг тус тус шалгаруулж тусгай шагналаар шагнана.

Ес.Тэмцээнийг дүгнэх журам

9.1.Тэмцээний төрөл тус бурд Нэг, Хоёр, Гуравдугаар байр шалгаруулж, багийн дүнг төрөл тус бурд нэгтгэж, нийлбэр дүнгээр 1-3 дугаар байр эзлүүлэн шалгаруулна.

9.2.Тэмцээний нийлбэр дүнг гаргахдаа дараах байдлаар оноо өгч нэгтгэнэ.

9.2.1.Сагсан бөмбөг 1 оноо

9.2.2. Волейбол 1 оноо

9.2.3. Ширээний теннис 1 оноо

9.2.4. Дартс 1 оноо.

Төрөл тус бурийн эхний хэсгээс хасагдсан баг 10-13 оноо, дараагийн бүсээс хасагдсан баг 8 оноо авна.

9.3.Тэмцээний шүүгч тоглолтын кодексыг гаргаж, тоглолтын хуваарийг хийн тэмцээний тоглолтын журмыг танилцуулж, баг тамирчдыг амжилтаар нь байр эзлүүлж, дүнг ерөнхий шүүгчид өгнө.

9.4.Тэмцээнийг бага онооны системээр зохион байгуулж, онооны нийт дүнгээр, хэрэв багуудын нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд медалийн чанараар байр эзлүүлнэ.

9.5.Оноо болон медалын чанар тэнцвэл багийн спортын медаль эрэмбийн эхэнд тооцно.

Техник, зохион байгуулалтын дэд ажлын хэсэг

Шүүхийн ерөнхий зөвлөлийн
даргын 2023 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн
131 дугаартай тушаалын 2 дугаар хавсралт

“ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО”
СЭДЭВТ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирэх 10 жилд шүүх эрх мэндлийн хүрээнд хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээг танилцуулж, “Шүүх эрх мэндлийн хөгжлийн бодлого”-ын баримт бичгийн төсөл, түүний үзэл баримтлалыг танилцуулах, тогтвортой мэргэшсэн шүүхийн захиргааны албан хаагчийг хэрхэн бэлтгэх, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцүүлэг хийхэд оршино.

Хоёр. Үйл ажиллагаа:

- Илтгэл;
- Танилцуулга;
- Хэлэлцүүлэг;
- Бусад арга хэмжээ.

Гурав. Хамрах хүрээ, оролцогч:

Бүх шатны шүүхийн захиргаа, үйлчилгээний 1387 албан хаагчид оролцоно.

Дөрөв. Зохион байгуулагч:

Шүүхийн ерөнхий зөвлөл

Тав.Хамтран зохион байгуулагч:

Шүүхийн захиргааны ажилтны холбоо

Зургаа. Зохион байгуулах газар:

Төрийн ордны Их танхим

Долоо. Хугацаа:

2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр

Найм.Хэлэлцүүлгийн сэдэв

- Шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого, цаашдын стратеги зорилтууд;
- Бие даасан, мэргэшсэн тогтвортой шүүхийн захиргаа;
- Шүүхийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд цахим, дижитал шилжилтийг нэвтрүүлэх нь;
- Шүүхийн захиргааны талаарх олон улсын туршлага.

Ёс. Үр дүн:

Шүүх эрх мэдлийн мэдээллийн технологи болон шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого нэвтрүүлж буйтай холбогдуулан нийт шүүхийн захиргааны ажилтнуудыг мэдээллээр хангах, нэгдсэн нэг ойлголттой болох, нийт шүүхийн захиргааны ажилтнуудын дунд анх удаагаа хэлэлцүүлэг зохион байгуулж буйгаараа онцлог болно.

---Оо---